ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ
(Спортын клуб-Тамирчин)

20.... он .... сар .... өдөр АЙМАГ, ХОТ

Монгол улсын Иргэний хууль, Биеийн тамир, спортын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн

Нэг талаас Монгол улс, Улаанбаатар хот, ... дүүрэг, ... хороолол, ... хороо, ... тоот хаягт байрлах ..... регистрийн дугаартай Спортын клуб /цаашид "Клуб" гэх/, түүнийг төлөөлж ..... албан тушаалтай ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... ,

Нөгөө талаас Монгол улс, ...хот, аймаг ..... дүүрэг, ... хороолол, ... хороо, ... тоот хаягт оршин суух ..... регистрийн дугаартай ..... овогтой ..... /цаашид "Тамирчин" гэх/, нар /цаашид хамтад нь "Талууд", тус тусад нь "Тал" гэх/ сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцож дараах нөхцөлөөр байгуулав.

Тамирчин насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч энэхүү гэрээнд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд оролцоно

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Тамирчин Клубт харьяалагдан тухайн спортын төрлөөр хичээллэх, бэлтгэл сургуулилалтад хамрагдах, тэмцээн уралдаанд оролцох, спортын ур чадвар, амжилтаа дээшлүүлэхтэй холбоотой Талуудын эрх, үүрэг, хариуцлага болон хамтын ажиллагааны нөхцөлийг зохицуулахад оршино.

1.2. Талууд хамтын ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, спортын тухайн төрлийн олон улсын болон үндэсний холбооны дүрэм, тэмцээний журам, Клубийн дүрэм, ёс зүйн хэм хэмжээг баримтална.

1.3. Энэхүү гэрээ нь хөдөлмөрийн харилцааг зохицуулах хөдөлмөрийн гэрээг орлохгүй. Талуудын харилцаа хөдөлмөр эрхлэлтийн шинжтэй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулна.

1.4. Тамирчин нь Клубт харьяалагдаж байгаагаар мэргэжлийн тамирчин, эсхүл Клубийн ажилтан гэж автоматаар тооцогдохгүй.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

2.1. Тамирчин нь Клубийн үйл ажиллагаа, тухайн спортын төрлийн бэлтгэл сургуулилалт, тэмцээн уралдаанд оролцох бөгөөд Клуб нь гэрээнд заасан нөхцөлөөр бэлтгэл хийх орчин, зохион байгуулалт, дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Тамирчны харьяалагдах спортын төрөл, баг, насны ангилал, бэлтгэл сургуулилалтын үндсэн хуваарийг талууд харилцан тохиролцож тогтооно.

2.3. Талууд гэрээний хэрэгжилтийн талаар харилцан мэдээлэл авах, тайлбар хүсэх, шаардлагатай тохиолдолд тайлан гаргуулах эрхтэй.

2.4. Талууд гэрээний үүргээ биелүүлэхдээ бие биенийхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, хууль тогтоомж болон гэрээний нөхцөлийг мөрдөнө.
2.5. Гэрээний хугацаа ..... сар/жил байна. Гэрээ ..... оны .... дугаар сарын ....-ны өдрөөс ..... оны .... дугаар сарын ....-ны өдөр хүртэл хүчинтэй байна.
2.6. Гэрээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө аль нэг Тал гэрээг сунгахгүй тухай бичгээр мэдэгдээгүй бол Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг сунгаж болно.
2.7. Гэрээний хугацааг сунгах, өөрчлөх асуудлыг бичгээр үйлдсэн гэрээний нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулна.

ГУРАВ. КЛУБИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Клубийн үүрэг

3.1. Гэрээ байгуулсан Тамирчинд Клубийн дүрэм, журам, ёс зүйн дүрэм, тухайн спортын холбооны дүрэм, тэмцээний журам болон допингийн эсрэг холбогдох зохицуулалтыг танилцуулах;
3.2. Тамирчны бэлтгэл сургуулилалтад шаардлагатай боломжит бэлтгэлийн орчин, заал, танхим, талбай, тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;
3.3. Бэлтгэл сургуулилалт явуулах орчин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах арга хэмжээ авах;
3.4. Тамирчны ур чадвар, бэлтгэлжилтийн түвшин, нас, эрүүл мэндийн байдалд тохирсон бэлтгэл сургуулилалтын зохион байгуулалтад анхаарах;
3.5. Тэмцээн уралдаанд оролцуулахтай холбоотой бүртгэл, мэдүүлэг, лиценз болон бусад шаардлагатай материалыг боломжит хугацаанд бүрдүүлэх;
3.6. Допингийн эсрэг дүрэм, хориотой бодис, эм бэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний талаар тамирчинд мэдээлэл өгөх, шаардлагатай сургалт, зөвлөгөө зохион байгуулах;
3.7. Тамирчны эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүссэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээ авах, яаралтай тусламж авахад дэмжлэг үзүүлэх;
3.8. Гэрээнд тусгайлан тохиролцсон санхүүгийн дэмжлэг, зардал, урамшууллыг хугацаанд нь олгох;
3.9. Тамирчны эрх, нэр төр, хувийн нууц, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
3.10. Тамирчны санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, боломжит хугацаанд шийдвэрлэх;
3.11. Тамирчинд дарамт шахалт, ялгаварлан гадуурхалт, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

Клубийн эрх

3.12. Тамирчнаас гэрээгээр хүлээсэн үүрэг, Клубийн хууль ёсны дүрэм, журам, спортын ёс зүйн хэм хэмжээг биелүүлэхийг шаардах;
3.13. Тамирчны бэлтгэл сургуулилалт, тэмцээний оролцоо, спортын амжилтад үндэслэн баг, бүрэлдэхүүн, тэмцээнд оролцох сонгон шалгаруулалт хийх;
3.14. Тамирчны бэлтгэлжилт, ур чадвар, сахилга бат, тэмцээний оролцооны талаар үнэлгээ хийх;

3.15. Тамирчныг Клубийн нэрийн өмнөөс тэмцээн, уралдаан, сургалт, бусад спортын арга хэмжээнд оролцохыг санал болгох;
3.16. Тамирчны ур чадвар, боловсрол, мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын сургалт, цугларалтад хамруулах санал гаргах;
3.17. Тамирчин гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд тайлбар авах, зөрчлийг арилгахыг шаардах, гэрээнд заасан болон хууль нийцсэн арга хэмжээ авах;
3.18. Тамирчны зөвшөөрөл болон хууль тогтоомжид нийцүүлэн түүний нэр, зураг, дүрс бичлэгийг Клубийн үйл ажиллагааг сурталчлахад ашиглах.

ДӨРӨВ. ТАМИРЧНЫ ЭРХ, ҮҮРЭГ

Тамирчны үүрэг

4.1. Клубийн дүрэм, журам, ёс зүйн дүрэм болон тухайн спортын төрөл, тэмцээн уралдааны холбогдох дүрмийг мөрдөх;
4.2. Тамирчин нь тухайн клубийн эрх бүхий албан тушаалтны өгсөн заавар, зөвлөмж, хуваарийн дагуу бэлтгэл дасгалжуулалт болон уралдаан тэмцээнд оролцох;
4.3. Сургалт дасгалжуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу бэлтгэл, дасгалжуулалт хийж, цагийн хуваарийг чандлан баримтлах, бэлтгэл таслахгүй байх;
4.4. Тамирчин нь бэлтгэл сургуулилалт, тэмцээний явцад болон өдөр тутмын амьдралдаа гарсан эрүүл мэндийн байдал, бэртэл гэмтэл, өвчлөлийн талаар Клубт боломжит хугацаанд буюу хамгийн хожимдоод ажлын 3 хоногийн дотор үнэн зөв мэдэгдэх үүрэгтэй.
4.5. Допингийн эсрэг холбогдох дүрэм, стандарт, хууль тогтоомжийг мөрдөх, хориотой бодис хэрэглэхээс зайлсхийх;
4.6. Эм, эмийн бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэрэглэхдээ хориотой бодис агуулсан эсэхийг нягталж, шаардлагатай тохиолдолд эмч, допингийн эсрэг эрх бүхий байгууллагаас зөвлөгөө авах;
4.7. Клубийн өмч хөрөнгө, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслийг ашиглахдаа анхаарал болгоомжтой хандах;
4.8. Бэлтгэл сургуулилалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл, Клубийн өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй мэдэгдэх;
4.9. Клубийн нэр хүнд, бусад тамирчин, дасгалжуулагч, ажилтны нэр төр, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
4.10. Тамирчин нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Клубийн шийдвэр, зардлаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон шинжилгээний үзлэгт хамрагдах ба Клуб нь тамирчны эрүүл мэндийн байдалд хяналт тавина.
4.11. Тамирчин нь бэлтгэл сургуулилалт хийх тоног төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүс байдал, эвдрэл гэмтэл гарсан тухай дасгалжуулагч болон Клубт нэн даруй мэдэгдэх бөгөөд аюулгүй байдлын талаар санал хүсэлт гаргах эрхтэй.
4.12. Тамирчин нь клубийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллагын тэмцээн уралдаан болон спорттой холбоотой аливаа арга хэмжээнд оролцохыг хориглоно.

4.13. Тамирчин нь Клубийн зөвшөөрөлгүйгээр өөрийн санаачилгаар оролцсон үйл ажиллагааны явцад бэртэл, гэмтэл авсан бол уг үйл ажиллагаатай холбоотой зардал, хариуцлагыг тухайн үйл ажиллагааны нөхцөл, талуудын буруутай үйлдэл, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ. Энэхүү заалт нь Клубийн хуульд заасан үүрэг болон өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүлээх хариуцлагыг үгүйсгэхгүй.

4.14. Тамирчин нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгэх явцад өвдсөн, гэмтэж бэртсэн эсвэл хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд ажлын 3 хоногийн дотор клубт мэдэгдэх үүрэгтэй.

4.15. Тамирчин нь ямар нэгэн ойлгомжгүй асуудлаас үүдэн, багийг орхих оролдлого хийх ба өөр бусад тамирчидыг уриалах үйлдэл хийж болохгүй.

4.16. Тамирчин өөрөө дур мэдэн өөр багт шилжихгүй байх, өөр багийн тамирчинтай солихгүй байх

4.17. Тамирчин нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, урьдчилан мэдэгдэлгүйгээр батлагдсан бэлтгэл сургуулилалтыг тасалсан тохиолдолд Клуб тухайн зөрчлийн нөхцөл байдал, давтамж, үр дагаврыг харгалзан тайлбар авах, сануулах болон Клубийн дотоод журам, холбогдох хууль тогтоомжид нийцсэн сахилгын арга хэмжээ авах эрхтэй. Бодит хохирол учирсан бол түүнийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу нөхөн төлүүлнэ.

4.18. Тамирчин нь Клубийн ивээн тэтгэгч, албан ёсны түнш байгууллагын хууль ёсны ашиг сонирхолтой шууд зөрчилдөх сурталчилгаа, хамтын ажиллагаа болон Клубийн нэр, лого, өмчийн эрхийг ашиглах үйл ажиллагааг Клубийн урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлэхгүй. Бусад хувийн сурталчилгаа, хамтын ажиллагааны асуудлыг талууд харилцан тохиролцоно.

4.19. Гэрээтэй холбогдуулан олж авсан мэдээ, мэдээллийг бусад тамирчид, дасгалжуулагчид болон клубтэй холбогдолтой аливаа мэдээлэл, баримт материал, дотоод дүрэм, журам, энэхүү гэрээний аливаа нөхцөл, үнэ тариф, хөлс, тооцоолол, ажил зохион байгуулалтын нууцлалыг чанд хадгалах, өөрийн болон бусдын ашиг сонирхолд ашиглуулахгүй, задруулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүргийг хугацаагүйгээр хүлээнэ.

Тамирчны эрх

4.20. Тамирчин хүндэтгэн үзэх шалтгаанаар эсхүл өөрийн хүсэлтээр гэрээг хугацаанаас өмнө цуцлах бол 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Хэрэв Клуб гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ (тэтгэлэг/урамшуулал олгох, аюулгүй байдал хангах) зөрчсөн бол Тамирчин 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэн гэрээг нэг талын санаачилгаар шууд цуцлах эрхтэй;

4.21. Бэлтгэл сургуулилалт хийх заал, талбай, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цэвэр байдлын талаар Клубт шаардлага тавих, санал хүсэлт гаргах;

4.22. Гэрээнд заасан тэтгэлэг, урамшуулал, зардлыг хугацаанд нь шаардан авах, шаардлагатай тохиолдолд өөрийн хүсэлтээр эмнэлгийн үзлэгт хамрагдах.

ТАВ. САНХҮҮЖИЛТ БОЛОН ХАНГАМЖИЙН ТАЛААР

5.1. Клуб нь Тамирчинд сар бүр ..... төгрөгийн "Бэлтгэлийн тэтгэлэг / Урамшуулал" олгоно (Хуульд заасан хувь хэмжээ, журмын дагуу хувь хүний орлогын албан татвар болон холбогдох суутгалыг хийнэ. Хэрэв Талууд хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуульд зааснаар төлнө).

5.2. Тухайн жилд зохиогдох уралдаан тэмцээн, бэлтгэл цугларалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Тамирчныг тэмцээний хувцас, хэрэглэл, хоол, байр, тээврийн зардлаар хангах асуудлыг Хавсралт №2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3. Тив, дэлхий, олон улсын чанартай албан ёсны уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргасан Тамирчны тэтгэлэг, урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг Клубийн удирдлага хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд холбогдох өөрчлөлтийг гэрээний нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулна.

5.4. Клуб нь олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргаж, зохион байгуулагч байгууллагаас олгосон албан ёсны мөнгөн шагнал, урамшууллыг тухайн тэмцээн дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор Тамирчны дансанд шилжүүлнэ. Багийн шагналын фонд нь тэмцээний хожлоос авсан албан ёсны шагналын .... %-иас бүрдэх ба хуваарилалтыг Хавсралтаар баталгаажуулна.

5.5. Тамирчин нь Клубийн зохион байгуулсан бэлтгэл сургуулилалт, тэмцээн уралдаанд оролцох явцад гэмтэж бэртсэн тохиолдолд Клуб нь даатгалын гэрээ болон хууль тогтоомжид заасны дагуу эмчилгээний зардлыг хариуцах бөгөөд эмчлүүлж буй хугацаанд (3 сар хүртэл) энэхүү гэрээний 5.1-д заасан тэтгэлэг/урамшууллын .... %-ийг олгоно.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ БА БУСАД НӨХЦӨЛ

6.1. Талууд гэрээний хугацаанд байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл (гал түймэр, үер, цар тахал, улс орны хэмжээний онцгой нөхцөл байдал, эрх бүхий байгууллагын хориг арга хэмжээ гэх мэт)-ийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ тухай нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэх бөгөөд нөхцөл байдал арилмагц талууд гэрээг хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцоно.

6.2. Тамирчин гэрээний хугацаа дуусгавар болсны дараа өөр спортын клубт чөлөөтэй шилжих эрхтэй. Харин гэрээний хугацаа дуусахаас өмнө өөрийн санаачилгаар Клубээс гарах буюу өөр клуб руу шилжих хүсэлт гаргасан тохиолдолд тухайн спортын холбооны дүрэм болон Клубийн зүгээс тамирчны сургалт, бэлтгэл, тэмцээнд зориулан зарцуулсан бодит хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг талуудын урьдчилан байгуулсан тохиролцооны дагуу барагдуулсны үндсэн дээр шилжилтийг шийдвэрлэнэ.

6.3. Энэхүү гэрээнээс үүссэн болон түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд үүссэн аливаа маргаан, зөрчлийг эхлээд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэрэв зөвшилцөлд хүрэхгүй бол уг маргааныг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хянан шийдвэрлэх дүрмийн дагуу эцэслэн шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙХ

7.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд талууд бичгээр саналаа солилцсоны үндсэн дээр гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажсанаар нэмэлт, өөрчлөлт нь гэрээний адил хүчин төгөлдөр болно.

7.2. Тамирчин нь гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, допингийн эсрэг дүрэм зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон, Клубийн хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулсан болон гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасан бусад үндэслэл бий болсон тохиолдолд Клуб гэрээг цуцлах асуудлыг холбогдох хууль тогтоомж, гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ. Гэрээг цуцлахын өмнө Тамирчинд тайлбар гаргах боломж олгож, гаргасан шийдвэрийг бичгээр мэдэгдэнэ.

7.3. Гэрээний хаяг өөрчлөгдсөн тохиолдолд нөгөө талдаа ажлын 5 хоногийн дотор Клубийн цахим шуудан, албан ёсны цахим хаягт мэдэгдэнэ.

7.4. Гэрээг Монгол хэл дээр, төрийн албан ёсны бичгээр, хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг нэг хувийг хадгалах ба хувь тус бүр нь хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна.

8. Талуудын хаяг:

"Клуб" тал	"Тамирчин" тал
Хаяг: _____	Хаяг: _____
_____	_____
Утас: _____	Утас:_____
Цахилгаан шуудангийн хаяг: _____	Цахилгаан шуудангийн хаяг:_____
_____	_____
Банкны харилцах дансны дугаар: _____	Банкны харилцах дансны дугаар: __
_____	_____
Гарын үсэг _____	Гарын үсэг _____

Тамирчин насанд хүрээгүй бол:
Хууль ёсны төлөөлөгч
(Эцэг, эх, асран хамгаалагч)
..... овогтой .....

Регистрийн дугаар: .....,
Хаяг: .....,
Утас: .....

Гарын үсэг: _____